



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 02 сарын 28-ны
өдрийн 432 дугаарт бүртгэгдсэн

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 221 дүгээр тогтоолоор баталсан "Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам", Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. Орхон аймгийн Баян-Өндөр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг индексжүүлж, хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан тарифыг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК /Л.Эрхбаатар/, "Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ" ОНӨХК /Д.Бүүвэйбаатар/-д тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.
4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 215 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.АМАРСАНАА

Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын 1-3-д оруулав.

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
D:\All\Khoroonii khural\Khoroonii khural 2019

2019 оны 03 сарын 25-ний өдөр

Эрчим хүчний зохицуулах хорооны
2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн
121 дүгээр тогтоолын хавсралт

Захирааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 03 сарын 28-ны
өдрийн 4321 дүгээрт бүртгэгдэв.

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м ³	504.00
		Төг/ГДж	7,854.00
2	Салхилуулга	Төг/ГДж	3,042.00
3	Албан байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м ³	2,060.00
		Төг/ГДж	1,717.00
		Төг/хүн	5,955.00
4	Технологийн уур	Төг/ГДж	8,533.00

2. Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "О"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	506.00
		Төг/ГДж	3,421.00
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Халаалтын улиралд Төг/хүн	1,870.00
		Халаалтын бус улиралд Төг/хүн	2,806.00
		Усны зарцуулалтаар Төг/м ³	2,500.00
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф		
3.1	40 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,300.00
3.2	41 м ² -аас 80 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	5,500.00
3.3	81 м ² -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	11,000.00

ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
.....
2019 оны 03 сарын 25-ний өдөр

“ЭРДЭНЭГИЙН ДЦС” ТӨХК



ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ХАНГАХ, ХЭРЭГЛЭХ ГЭРЭЭ

Хэрэглэгч байгууллагын нэр:
.....

Гэрээний дугаар:.....

“ЭРДЭНЭТИЙН ДЛС” ТӨХК

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ХАНГАХ, ХЭРЭГЛЭХ ГЭРЭЭ

АЖ АХУЙН ХАРИЛЦААНЫ ДҮРЭМ

- 2.2.Иргэн, хуулийн этгээд дулааны эрчим хүчээр хангах гэрээг байгуулахаас өмнө дараах шаардлагыг хангасан байна:
- 2.2.1.олгодсон техникийн нөхцөлийн шаардлагыг хангасан байх;
- 2.2.2.хэрэглэсэн дулааны эрчим хүчний тооцоог нийлж баталгаажуулах, өр төлбөрөө бүрэн барагдуулсан байх;
- 2.2.3.шугам сүлжээний эзэмшлийн заагийг хоёр тал харилцан тохиролцож баталгаажуулсан байх;
- 2.2.4.тоолуур, хэмжих хэрэгслийг шалгаж эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байх;
- 2.2.5.дулааны шугам сүлжээ, тоноглолд хийх засвар үйлчилгээг зохих журмын дагуу хийж, аюулгүй, найдвартай байдлыг хангасан байх;
- 2.2.6.дулааны шугам сүлжээний хамгаалалтын зурваст хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулаагүй байх;

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭХ ДҮРЭМ

54. Эрчим хүчний улсын байцаагч хангагчийн эрх бүхий ажилтан нь Эрчим хүчний тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан болон дараахь тохиолдолд эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлнэ:
- 1/ дулааны эрчим хүчийг гэрээнд заагаагүй зориулалтаар ашигласан, ус, дулааны алдагдлыг нормд заасан хэмжээнээс хэтрүүлсэн;
- 2/ эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөл бүрдүүлээгүй буюу техникийн нөхцөлийн шаардлагыг зөрчсөн, зөвшөөрөлгүй барилга байгууламж холбож дулаан авсан;
- 3/ хангагчаас тооцоолж битүүмжлэн тавьсан, тохируулах хэрэгсэл /сopлo, шайба/-ийг дур мэдэн өөрчлөх буюу авах замаар бусдын дулаан хангамжийг доголдуулсан;
- 4/ тооцооны хэмжүүрт оруулахгүй зүй бусаар холболт хийж дулаан /уур, ус/ авч ашигласан;
- 5/ хэрэглэсэн дулааны болон буцаагаагүй хувирсан усны төлбөрийг дараа сарын 10-ны дотор төлөөгүй.
55. Улсын байцаагч болон хангагчийн эрх бүхий ажилтан хэрэглэгчийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх тухай шийдвэртээ шалтгааныг тодорхой зааж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ, тоолуур болон шаардлагатай бусад хэрэгслийг битүүмжилнэ.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХҮҮЛЬ ТОГТООМЖ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХҮҮЛЬ

9 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх

9.1.5. Эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ангийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох;

28 дугаар зүйл. Эрчим хүчээр хангах гэрээ

28.5. Хэрэглэгч энэ хуулийн 27.5-д заасны дагуу мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор хангагчтай байгуулсан гэрээндээ зохих өөрчлөлт оруулах бөгөөд гэрээндээ өөрчлөлт оруулаагүй нь энэхүү өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй. /27.5. Зохицуулах хороо нь эрчим хүчний тарифт орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгчид мэдэгдэх буюу хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдэгдэнэ/

31 дүгээр зүйл. Эрчим хүчний төлбөр хийх, торгууль ногдуулах

31.3. Эрчим хүчээр хангагч нь гэрээнд заасан хугацаанд эрчим хүчний төлбөрөө төлөөгүй буюу зохих ёсоор төлөөгүй хэрэглэгчид хугацаа хэмжигдүүлсэн хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0.5 хүртэл хувьтай тэнцэх алданг ногдуулна. 31.4. Энэ хуулийн 31.2, 31.3-т заасан торгууль, алдангийн хэмжээ нийлүүлэгчгүй буюу дутуу нийлүүлсэн эрчим хүчний үнийн дүнгийн буюу төлөөгүй төлбөрийн 50 хувиас хэтэрч болохгүй.

32 дугаар зүйл. Эрчим хүчний хангамж, хэрэглээг түгээлгүүлэх

32.2. Эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан дараахь тохиолдолд хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг зөрчлийг аригах хүртэл хугацаагаар түгээлгүүлнэ:

32.2.1. Эрчим хүч хэрэглэгчийн төлбөрөө хугацаанд нь төлөөгүй;

32.2.2. Эрчим хүчний тоолуур, хэмжүүр, тэдгээрийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтын дүр мэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан;

32.2.3. Тоолуургүй тохиолдолд гэрээнд тусгагдаагүй хэлбэрээр эрчим хүч хэрэглэсэн;

32.2.4. Хангагчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн хэрэглээний хүрээндээ өөр хэрэглэгчийг эрчим хүчээр хангасан;

32.2.5. Байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн, тулшийн хомсдол бий болсон, эрчим хүчний хангамжид осол, саатал гарсан, хүний амь нас, эд хөрөнгөд аюул учрах, гал түймэр гарах нөхцөл үүссэн;

32.2.6. Хэрэглэгч өөрийн байранд нэвтрэн үзлэг хийх боломжийг хангагчийн эрх бүхий ажилтанд олгоогүй.

32.3. Эрчим хүчний хяналтын улсын байцаагч энэ хуулийн 32.2-т зааснаас гадна дараахь тохиолдолд хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг зөрчлийг аригах хүртэл хугацаагаар түгээлгүүлнэ:

32.3.1. Хэрэглэгчийн эрчим хүчний тоног төхөөрөмж, шугам сүлжээ нь ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй болсон;

32.3.2. Эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөлийг зөрчсөн;

32.3.3. Гэрээгээр тогтоосон цахилгаан чадлын хэрэглээг хэтрүүлсэн.

33 дугаар зүйл. Шугам сүлжээний хамгаалалтын зурвас

33.1. Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Хангагч:

Батлав: "Эрдэнэтийн ДЦС"ТӨХК-ийн

Гүйцэтгэх захирал

Хэрэглэгч

Батлав:

Б.БАТ-ЭРДЭНЭ

Дарга:

20...оны...сарын ...-ны өдөр

Дугаар:.....

Эрдэнэт хот

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТУХАЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Хангагч гэж нэрлэгдэх "Эрдэнэтийн ДЦС"ТӨХК-ийг төлөөлж

албан тушаалтай овогтой

хэрэглэгчийг төлөөлж албан тушаалтай

..... овогтой нар 20 оны сарын

.....-ны өдрөөс 20.....онысарын-ны өдрийг хүртэл хугацаагаар энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Хангагч ба хэрэглэгч нь Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, Дулааны эрчим хүчийг хэмжих, тооцох дүрэм, Холболтын журам, Аж ахуйн харилцааны дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хангагч-хэрэглэгчийн хооронд дулааны эрчим хүчээр хангах гэрээг өмчлөлтэй эсхүл өмчлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй байгуулж мөрдлөгө болгоно.

1.2. Дулааны шугам тоноглолын аваарь осолгүй найдвартай ажиллагааг хангаж дулааны эрчим хүчийг зүй зохистой үр ашигтай зарцуулахын тулд хангагч ба хэрэглэгч нь ДЦС-ний "Ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм", "Техник ашиглалтын дүрэм", "Ашиглалтын зааврууд"-ыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажиллана.

1.3. Хангагч, хэрэглэгч нь дулаанаар хангах гэрээг жил бүрийн халаалтын улирал эхлэх хугацаанд буюу Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон хугацаанд байгуулж мөн тогтоосон халаалтын улирал дуусахад гэрээг дүгнэж, тооцоо нийлэн акт үйлдэнэ.

1.4. Дулааны эрчим хүчний үнийн өөрчлөлтийг эрчим хүчний хуулийн 28-ын 5-д зааснаар мөрдөн ажиллана. Хангагчаас хэрэглэгчийн хэрэгцээнд нийлүүлэх дулааны эрчим хүчний төрөл, тоо хэмжээг доорхи хүснэгтээр тооцохоор тохиролцов.

ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ

Батлав: "Эрдэнэтийн ДЦС"ТӨХК-ийн
Батлав:.....
Гүйцэтгэх захирал
Дарга:.....

[illegible]

20...оны.....сарын.....-ны өдрөөс

20... оны ...сарын ...-ны өдөр хүртэл сунгав.

Хангагчийг төлөөлж

Хэрэглэгчийг төлөөлж

...../

.....! (гарын үсэг) (нэр)

20...оны...сарын ...-ны өдөр

[illegible]

ХОЕР. ХАНГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Хэрэглэгчийн дулааны шугам тоноглолын угсралт засвар болон угаалт шахалтанд өөрийн төлөөлөгчөөр хяналт тавилж дулаан авах шаардлага хангасан эсэхийг тогтоосон актаар гэрээ хийх техникийн үндэслэлийг бүрдүүлнэ.

2.2. Хангагч шаардлагатай гэж үзвэл хэрэглэгчийн төлбөрийн чадварын талаар харилцагч банкаас гаргасан баталгааг үндэслэн дулааны эрчим хүчээр хангах гэрээг байгуулж болно.

2.3. Техникийн болон санхүүгийн шаардлага хангасан хэрэглэгчтэй гэрээ байгуулсны дараа хэрэглэгчийн дулааны зангилаанд тавих тохируулах хэрэгсэл (согло, шайба)-ийн тооцрог хийлгэж бэлтгүүлээд өөрийн төлөөлөгчийг байлцуулан тавиулж лавдаж сүлжээний усаар дүүргэж дулаан өгнө.

2.4. Хэрэглэгчдэд өгөх сүлжээний усны хэмийг станцын коллектор дээр гадна агаарын хэмтэй уялдуулан батлагдсан графикийн дагуу зөвшөөрөгдсөн хэлбэлзэл дотор нь багтаан барих бөгөөд даралтыг хэрэглэгчийн оруулга дээр хотын сүлжээний горимын тооцоонд заагдсан хэмжээгээр тус тус барьж ажиллана.

2.5. Долоо хоног тутам өөрийн төлөөлөгчөөр хэрэглэгчийн дулаан хангамжийн байдлыг шалгуулж, халаалтын чанарыг сайжруулах, дулааны алдагдлыг багасгах, илэрсэн зөрчлийг арилгуулах, гомдол саналыг барагдуулах арга хэмжээ авна.

ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ

Батлав. "Эрдэнэтийн ДЦСТӨХК-ийн

Батлав:.....

Гүйцэтгэх захирал

Дарга:.....

№	Үзүүлэлт	Дулааны хэрэглээ						Дулаан хэрэглэх хугацаа		Тайлбар
		М ²	М ²	ГДЖ	конд	Хүн тоо	XXV	Үйлд	Тариф	

20... оны...сарын...-ны өдрөөс

20... оны...сарын...-ны өдөр хүртэл сунгав.

Хангагчийг төлөөлж

Хэрэглэгчийг төлөөлж

..... /
(гарын үсэг) (нэр)

..... /
(гарын үсэг) (нэр)

20... оны...сарын...-ны өдөр

2.6. Дулаан хангамжийн төлөвлөгөөт таслалтын талаар 24-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдэж, аваарын таслалтыг урьдчилан хугацаа тогтоохгүй таслаж, тасалсны дараа мэдэгдэх ба тасалсан шалтгааныг тодруулж, гэмтлийг устгасны дараа дулаан хангамжийг сэргээнэ.

2.7. Дулаан хангамжийн доголдол гарсан тухай дуудлагад очиж шалтгааныг тодруулан хангагчийн ажиллагаанаас хамаарсан доголдлыг хоногт нь багтаан хэвийн болгоно. Хэрэглэгч сүлжээний усны хэмийг өндөржүүлсэнээс хотын төв шугамын тохируулгад нөлөөлж бусад хэрэглэгчдийн халаалт доголдуулахад хүрвэл дулааны хэрэглээг хязгаарлах ба зөрчлийг арилгахыг шаардах эрхтэй

2.8. Хэрэглэгчийн дулаан хангамжийг сайжруулахад мэргэжлийн боломжтой бүх туслалцааг үзүүлнэ.

2.9. Хангагч нь хууль тогтоомж болон гэрээнд зааснаас бусад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дулааны эрчим хүчээр хангах гэрээ, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзах эрхгүй.

2.10. Хангагч нь хууль дүрэм, заавар, гэрээнд заагаагүй нөхцөл болзол тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарлахгүй.

2.11. Хангагч нь гэрээлсэн эрчим хүчний үнэ тариф, чанарт орох өөрчлөлтийн талаар түүнийг дагаж мөрдөж эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгчдэд мэдэгдэх буюу хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр зарлаж, гэрээндээ өөрчлөлт оруулна.

2.12. Дулааны шугам, тоног төхөөрөмжид нь усны алдагдал гарсан үед бусад хэрэглэгчдийг хэвийн хангахын тулд уг алдагдалтай хэрэглэгчийн дулааныг хангагч түдгэлзүүлж алдагдсан усны тооцрог гарган баталгаажуулж төлбөрийг тооцон авна.

2.13. Хэрэглэсэн эрчим хүчний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчийг эрчим хүчээр хангах, гэрээг цуцлах, эрчим хүчний хуулийн 33.1-д заасныг зөрчиж шугам сүлжээний хамгаалалтын зурваст буусан хэрэглэгчийг эрчим хүчээр хангахаас татгалзах эрхтэй.

2.14. Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр хэрэглэгчийг холбох эрхтэй.

2.15. Шугам сүлжээний хамгаалалтын зурваст үйл ажиллагаа явуулж байгаа ААН, хэрэглэгчдэд техникийн болон гэнэтийн хүчин зүйлийн улмаас учирсан хохирлыг хангагч байгууллага хариуцахгүй.

2.16. Хангагч нь дулаан хангамжийн горимын зөрчил, шугам тоног төхөөрөмжийн гэмтэлтэй холбоотой хэрэглэгчийн санал, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх ба дулааны эрчим хүч дутуу нийлүүлсэн, эрчим хүчээр хязгаарласан буюу тасалсан эрчим хүчний хэмжээг тоолуурын заалт, ээлжийн диспетчерийн албан ёсны тэмдэглэл, параметрийн мэдээ, хэрэглэгчийн дуудлагын бүртгэлийг үндэслэн төлбөрийн хасалтыг хийх үүрэгтэй

ГУРАВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Гэрээ байгуулахын тулд хэрэглэгч нь ЭХЗХ-ны 2018 оны 10-р сарын 11-ний өдрийн 292-р тогтоолоор батлагдсан Аж ахуйн харилцааны дүрмийн 2.2-р заалтанд заасан шаардлагыг хангасан байна.

3.2. Хэрэглэгч нь дулааны алдагдлыг багасгаж, ашиглалтыг сайжруулах, өрөө тасалгааны халаалтыг жигд байлгахын тулд дараах үүргүүдийг хүлээнэ.

ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ

Батлав. “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК-ийн

Батлав:.....

Гүйцэтгэх захирал

Дарга:.....

[illegible]

20...оны...сарын...-ны өдрөөс

20... онысарын ...-ны өдөр хүртэл сунгав.

Хангагчийг төлөөлж

Хэрэглэгчийг төлөөлж

..... /
(гарын үсэг)

..... / (гарын үсэг) (нэр)

20...оны...сарын-ны өдөр

1. Барилга байгууламжийн орц, цонх, хаалгыг сайтар дулаалах
2. Халаалт салхилуулгын системийн дотоод тохируулгыг бүрэн хийх
3. Буцах усны температурыг графикаас 4 хэмээс хэтрүүлэхгүй байх
4. Сүлжээний усны элдэв алдагдал гарахгүй байх ба гаргасан тохиолдолд хангагчийн тавьсан актанд гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй
5. Лац, ломбо бүрэн бүтэн байлгах
6. Хангагчийн зөвшөөрөлгүй, батлагдсан зураг төсөвгүй хэрэглэгчийг дулаанд нэмж холбох, барилгыг өргөтгөх, дулааны шугам узель, ДДС-ийн схемийг өөрчлөхгүй байх
7. Дулааны төв шугамын засварын хугацаанд өөрийн эзэмшлийн шугам тоноглолын засварыг чанартай хийж хангагчийн төлөөлөгчийн хяналтан дор уггаж цэвэрлэн шахаж шалгасан байх
8. Гэрээгүй буюу гэрээнд зааснаас илүү дулаан хэрэглэхгүй байх, сүлжээнийг уусыг асгах, зориулалтын бус зүйлд ашиглахыг хориглоно.
9. Авч байгаа дулааныг нэмэгдүүлэх, хаалгах бол 7 хоногийн өмнө хангагчид өөрийн биеэр ирж албан бичгээр хандан, гэрээнд өөрчлөлт оруулж, төлбөр тооцоог тохирно. Өмнөх тооцоо хуучин гэрээгээр зохицуулагдана.
10. Хэрэглэгч нь дараах эрхүүдийг эдэлнэ. Үүнд: Эрчим хүчээр хангагч гэрээгээний үүргээ зохих ёсоор биелүүлзгүйгээс эрчим хүч дутуу нийлүүлсэн, дулааны эрчим хүчний төлбөр тооцоог хийж, өр авлагыг барагдуулна.
11. Хэрэглэгч нь узелийг цэвэрхэн, эмх цэгцтэй байлгах дулааны болон усны тоолуурын бүрэн бүтэн байдлыг хариуцна.
12. Дулааны хэмжүүр ба хамааралгүй схемээр холбогдсон хэрэглэгчдийн нэмэлт усны шугам дээр тавьсан хэмжүүрийн заалт, шайба, сопло сольсон акт эзэрэг бичиг баримтуудыг үнэн зөв гаргаж баталгаажуулан төлбөр тооцоонд тусгах
13. Өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээ баталгаажуулалтыг бүрэн хариуцах
14. Түгээх зохицуулалттай эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах.
15. Дулааны тоолууртай хэрэглэгч дараах бичиг баримтын иж бүрдлийг өөр дээрээ байлгана. Үүнд:
 1. Дулааны тоолуур суурилуулах техникийн нөхцөл
 2. Дулааны тоолуур суурилуулсан, хүлээлцсэн акт
 3. Ээлжит баталгаажуулалт хийлгэсэн тохиолдолд тоолуур баталгаажуулсан гэрчилгээ
 4. Тоолуурын заалтыг хөтөлсөн хүснэгтийн нэг хувь
16. Тоолууртай хэрэглэгч тоолуурын заалтыг сар бүрийн 28-ны дотор хангагч дээр авчирч тооцоог хийнэ.
17. Шинээр дулааны болон уурын тоолуур суурилуулахдаа хангагчид тоолуурын техникийн нөхцөл хүссэн албан тоот өгнө.

ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ

Батлав. "Эрдэнэтийн ДЦС"ТӨХК-ийн

Батлав:.....

Гүйцэтгэх захирал

Дарга:.....

№	Үзүүлэлт	Дулааны хэрэглээ						Дулаан хэрэглэх хугацаа		Тайлбар
		М ³	М ²	ГДЖ	конд	Хүн тоо	XX	Үйлд	Фиф	
									авах	хаах

20... оны...сарын...-ны өдрөөс

20... оны...сарын...-ны өдөр хүртэл сунгав.

Хангагчийг төлөөлж

Хэрэглэгчийг төлөөлж

...../ (гарын үсэг) (нэр) (гарын үсэг) (нэр)

20... оны...сарын...-ны өдөр

Хангагчийн техникийн нөхцөл олгох эрх бүхий албан тушаалтан газар дээр нь үзэж техникийн нөхцөлийг олгож суурилуулах тоолуурын хүчин чадлыг тогтоож өгнө. Дулааны болон уурын тоолуур суурилуулахдаа тоолуур импортлох тусгай зөвшөөрөлтэй ААН-ээс тоолуур авах ба суурилуулах тусгай зөвшөөрөлтэй ААН-ээр монтажийн ажлыг хийлгэж хангагчийн эрх бүхий ажилтнаар шалгуулж, лацдуулж актын дагуу хүлээлцэнэ.

ДӨРӨВ. ДУЛААНЫ ҮНИЙН ТӨЛБӨР ТООЦОО

- Хэрэглэгч хэрэглэсэн дулааны эрчим хүчний төлбөрийг тухайн сардаа багтаан төлж байхаар тохиролцов.
- Хангагч, хэрэглэгч талууд Монгол улсын Эрчим хүчний хуулийн 9-р зүйлийн дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолоор баталсан дулааны эрчим хүчний үнэ тарифыг мөрдөнө.
- Зохицуулагчдын зөвлөлөөс дулааны үнэ тарифыг өөрчлөн тогтоосон тухай бүр нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлсэнээр шинэ тариф мөрдөгдөнө.
- Доорхи хавсралтанд тусгасан ЭХЗХ-ны 2019 оны 03-р сарын 25-ны өдрийн 121-р тогтоолоор батлагдсан тарифыг мөрдөнө.

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

- Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м ³	504.00
2	Салхилуулга	Төг/ГДЖ	7.854.00
3	Албан байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/ГДЖ	3.042.00
4	Технологийн уур	Төг/м ³	2.060.00
		Төг/хүн	1.717.00
		Төг/ГДЖ	5.955.00
		Төг/ГДЖ	8.533.00

- Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ³	506.00
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/ГДЖ	3.421.00
	Халаалтын улиралд	Төг/хүн	1.870.00
	Халаалтын бус улиралд	Төг/хүн	2.806.00
	Усны зарцуулалтаар	Төг/м ³	2.500.00
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф		
3.1	40м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3.300.00
3.2	41м ² –аас 80м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	5.500.00
3.3	81м ² –аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	11.000.00

4.5. Хэрэглэгч төлбөр тооцооны маргаантай асуудлаарх санал, хүсэлтээ хангагчид албан ёсоор мэдэгдэх ба хангагч мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.

4.6. Хангагч хэрэглэгчээс эрчим хүчний төлбөрийг бусад төлбөртэй хамт хийхийг шаардах эрхгүй

4.7. Дулааны хэрэглээг хэмжүүр тоолуураар тооцох хэрэглэгчид MNS 6241:2011 стандартын шаардлага ханган суурилуулсан байх ба "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" тухай хууль, Дулааны эрчим хүч, дулаан зөөгчийг хэмжих тооцох дүрмийг мөрдөнө.

4.8. Хэрэв хэрэглэгч байгууллага хэрэглэсэн эрчим хүчнийхээ үнийг хугацаандаа төлөөгүй удсан тохиолдолд Цахилгаан Дулааны Эрчим хүч, Нүүрсний Төлбөрийн тухай хуулийн 1 болон 2-р зүйлд заасны дагуу банкны байгууллага бичсэн алданги болон төлбөрийг хангагчийн нэхэмжлэлийн дагуу хэрэглэгчийн харилцах данснаас шууд хамт хийхээр тохиролцов.

4.9. Дулааны эрчим хүчний тооцоог тоолуураар хийж байгаа хэрэглэгчийн хэрэглэсэн дулааны эрчим хүчний тоо хэмжээн дээр "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм" Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм"-ийг үндэслэн дулааны шугамын алдагдлыг 5% нэмж тооцно.

ТАВ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1. Хангагч, хэрэглэгч нь Иргэний хууль, Эрчим хүчний хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, ЭДЦС ТӨХК хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэмд заасан хариуцлагыг хүлээнэ

5.2. Хэрэглэгч нь эрчим хүчний хууль, дулааны эрчим хүч ашиглах заалтуудыг үндэслэн дутуу өгөгдсөн дулаан үнийг хасч тооцож байна.

5.3. Хангагч нь гэрээнд заасан хугацаанд эрчим хүчнийхээ төлбөрийг төлөөгүй хэрэглэгчдэд хугацаа хожимдуулсны хоног тутамд төлбөрийн дүнгийн 0,5% хүртэл алданги ноогдуулна. Алдангийн хэмжээг төлбөрийн 50%-иас хэтрүүлэхгүй.

5.4. Эрчим хүчний тухай хуулийн 32-р зүйл, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 54, 55-р зүйлд заасны дагуу эрчим хүчний хангамж хэрэглээг түдгэлзүүлснээс гарах бүх хариуцлагыг хэрэглэгч өөрөө хүлээнэ.

5.5. ДЭХ-ээр хангагдаж байгаа хэрэглэгч нь сүлжээний буцах усны халууныг батлагдсан графикаас 4 хэмээс дээш хэмжээгээр өндөржүүлсэн тохиолдолд өндөржүүлсэн хэмд ноогдох ашиглахгүй буцаасан дулааны үнийг тооцож төлнө.

5.6. Хэрэглэгч гэрээнд зааснаас илүү ДЭХ авч ашигласан нь илэрсэн тохиолдолд нөхөн төлбөр төлнө.

5.7. Хэрэглэгч нь дулааны эрчим хүч дур мэдэн авсан тохиолдолд энэхүү гэрээний 5.4-т зааснаар хангагчийн зүгээс хэрэглээг түдгэлзүүлж энэ тухай зураг авалт хийн баримтжуулж, тухайн асуудлаар мэргэжлийн хяналтын албанд хандан акт гаргуулж улмаар хуулийн байгууллагад өгч шийдвэрлүүлнэ

ХАНГАГЧИЙН

Нэр, регистрийн дугаар:.....

Банкны нэр, дансны дугаар:.....

Хаяг:.....

Утасны дугаар:.....

Цахим хаяг:.....

ХЭРЭГЛЭГЧИЙН

Нэр, регистрийн дугаар:.....

Банкны нэр, дансны дугаар:.....

Хаяг:.....

Утасны дугаар:.....

Цахим хаяг:.....

Хангагчийг төлөөлж

Хэрэглэгчийг төлөөлж

(гарын үсэг)

(нэр)

(гарын үсэг)

(нэр)

20...оны...сарын...-ны өдөр

АЖ АХУЙН ХАРИЛЦААНЫ ДҮРЭМ

/Дулаанаар зохицуулалттай хангах тусгай Зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын/

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийн зорилго нь Эрчим хүчний тухай хуульд заасан дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчээс /цаашид “Хангагч” гэх/ хэрэглэгчийг дулаанаар хангахтай холбогдож үүссэн гэрээний нөхцөл, түүнд тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, чанарын үзүүлэлт, төлбөр тооцооны нөхцөлийг тусгасан хэм хэмжээг тодорхойлоход оршино.

1.2.Энэхүү дүрмийг хангагч, хэрэглэгч болон шинээр гэрээ байгуулахыг хүссэн иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

Хоёр. Гэрээний нөхцөл, шаардлага

2.1.Хангагч, хэрэглэгч нь Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм,Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, Дулааны эрчим хүчийг хэмжих, тооцох дүрэм, Холболтын журам, энэхүү дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Хангагч-хэрэглэгчийн хооронд дулааны эрчим хүчээр хангах гэрээ”-г өмчлөгчтэй, эсхүл өмчлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй байгуулна.

2.2.Иргэн, хуулийн этгээд дулааны эрчим хүчээр хангах гэрээг байгуулахаас өмнө дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1.олгогдсон техникийн нөхцөлийн шаардлагыг хангасан байх;

2.2.2.хэрэглэсэн дулааны эрчим хүчний тооцоог нийлж баталгаажуулах, өр төлбөрөө бүрэн барагдуулсан байх;

2.2.3.шугам сүлжээний эзэмшлийн заагийг хоёр тал харилцан тохиролцож баталгаажуулсан байх;

2.2.4.тоолуур, хэмжих хэрэгслийг шалгаж эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байх;

2.2.5.дулааны шугам сүлжээ, тоноглолд хийх засвар үйлчилгээг зохих журмын дагуу хийж, аюулгүй, найдвартай байдлыг хангасан байх;

2.2.6.дулааны шугам сүлжээний хамгаалалтын зурваст хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулаагүй байх;

2.3.Иргэн (айл өрх)-тэй байгуулах дулааны эрчим хүчээр хангах гэрээнд дараах нөхцөлийг тусгана.

2.3.1.дулаанытоо хэмжээ, төрөл;

2.3.2.дулааны эрчим хүчний чанар;

2.3.3.төлбөр тооцооны нөхцөл, тарифын төрөл;

2.3.4. талуудынэрх, үүрэг, хариуцлага;

2.3.5.дулааны эрчим хүчийг илүү, дутуу түгээснээс шалтгаалан үүссэн маргааныг шийдвэрлэх;

2.3.6.гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөл торуулах тухай;

2.3.7.гэрээний хугацааг тоогоор болон бичвэрээр давхар бичих;

2.3.8.шаардлагатай гэж үзвэл зарим хэрэглэгчдийн хувьд төлбөрийн батлан даалт гаргуулсан, барьцаа төлбөр төлсөн эсэх асуудлыг тусгах;

2.3.9.эзэмшлийн зааг /бүдүүвч, зургийн хамт/;

2.3.10.хэрэглэгчийн шаардлагатай мэдээлэл;

2.3.11.дулаанытөлбөр төлөх цэгүүд;

2.3.12.хангагчийн эрх бүхий ажилтнуудын хаяг, утас;

2.3.13.дулааны төлбөрийн тухай хангагчийн тодорхойлолт;

2.3.14.иргэн (өмчлөгч, эзэмшигч)-ий үнэмлэх, газрын гэрчилгээ, кадастрын зураг, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний баталгаат хуулбар болон баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, өмчлөгчийн итгэмжлэл, тоолуур, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ зэргийг хавсаргасан байна;

2.4.Хуулийн этгээдтэй байгуулах дулааны эрчим хүчээр хангах гэрээнд энэ зүйлийн 2.3-т зааснаас гадна дараах нөхцөлийг тусгана.

2.4.1.тоног төхөөрөмж, техникийн өгөгдлүүд;

2.4.2.төлбөр тооцооны хэмжих хэрэгслийн байршил, ашиглалтад хүлээн авсан тухай протокол, акт;

2.4.3.хэрэглэгч хуулийн этгээдийн төлбөрийн чадварын талаар харилцагч банкны байгууллагаас гаргасан баталгаа болон тэдгээрийн харилцах данснаас төлбөрийг банкны байгууллагаар шууд хийлгэх нөхцөл, төлбөрийн барьцаа;

2.4.4.эзэмшлийн заагаас тоолуур, төлбөр тооцооны хэрэгсэл хүртэлх алдагдлыг тодорхойлсон тооцоолол, алдагдлын хувь хэмжээ;

2.5.Хэрэглэгч нь барилга байгууламжийг өөр этгээдийн өмчлөл, эзэмшилд шилжүүлэх тохиолдолд хангагчтай байгуулсан гэрээг 7 хоногийн өмнө цуцалж, төлбөр тооцоог дуусгах ба шинэ эзэмшигч нь хэрэглэсэн дулааны эрчим хүчний төлбөр тооцоог дуусгасан тухай хангагч байгууллагаас тодорхойлолт авсан байна.

2.6.Хангагч, хэрэглэгч нь дулаанаар хангах гэрээг жил бүрийн халаалтын улирал эхлэх хугацаанд буюу Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон хугацаанд байгуулж мөн тогтоосон халаалтын улирал дуусахад гэрээгдүгнэж, тооцоо нийлэн акт үйлдэнэ.

2.7.Хэрэглэгчийн шугам сүлжээний эзэмшлийн заагийг тухайн шугам сүлжээний өмчлөлийн харьяаллаар тогтооно.

2.8.Дулаа нь тасалдлаас учирсан аливаа хохирлыг нөхөн төлөх талаар дулаанаар хангах гэрээнд тодорхой тусгасан байна.

2.9.Хэрэглэгч нь дамжуулах, түгээх шугам сүлжээний эзэмшлийн байдал, техникийн хувьд боломжтой нөхцөлд хангагч байгууллага сонгон үйлчлүүлэх эрхтэйгээр аж ахуйн харилцаанд оролцоно.

2.10.Хэрэглэгчийн эзэмшлийн шугам, тоноглолыг харилцан зөвшилцсөний үндсэн дээр гуравдагч этгээд өргөтгөн шинэчилсэн тохиолдолд ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдон гарах зардлыг хамтран хариуцна.

Гурав. Үйлчилгээний түвшин

3.1.Хангагч нь хэрэглэгчийг аж ахуйн гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын шаардлага хангасан дулаанаар найдвартай хангана.

3.2.Хангагч нь дулааны тасалдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, машин механизм, хүнхүч, тоног төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгана.

3.3.Хэрэглэгчийн захиалгаар ажил гүйцэтгэхэд бусад хэрэглэгчийн дулаан хангамжийг түр хугацаагаар түдгэлзүүлэх шаардлагатай бол түдгэлзүүлэхээс 24-өөс доошгүй цагийн өмнө хэрэглэгчид мэдэгдэнэ.

3.4.Хэрэглэгчдэд соёлтой үйлчилж, тэдний эрх ашигт нийцсэн төрөл бүрийн мэргэжлийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

3.5.Дулаан хангамж, чанарын үзүүлэлт, горим тохируулгатай холбоотой хэрэглэгчийн санал, хүсэлт өргөдлийг хүлээн авсан тухайн өдөрт багтаан шийдвэрлэх, төлбөр тооцоо, маргаантай асуудлаарх гомдлыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэнэ.

3.6.Хангагч нь орон сууцны барилгын ашиглалт, үйлчилгээг хүлээн авахдаа барилгын батлагдсан зураг төслийг тухайн орон сууцны бодит талбайн хэмжээтэй харьцуулан хянаж, холбогдох материалын хамт хүлээн авна.

3.7.Төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой дулаан хангамжийг түдгэлзүүлэх талаар хэрэглэгчдэд 72 цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

3.8.Хэрэглэсэн дулааны эрчим хүчний төлбөрийн нэхэмжлэл банканд очсоноос хойш алданги тооцож эхлэх болон дулааны эрчим хүчээр түдгэлзүүлж эхлэх хоногуудыг тус тус хэрэглэгчтэй байгуулж буй гэрээгээр зохицуулна.

Дөрөв. Дулааны эрчим хүчний чанарын үзүүлэлт

4.1.Хангагч нь дараах стандартуудаас гадна холбогдох барилгын норм ба дүрэм болон бусад эрх зүйн хэм хэмжээг мөрдлөгө болгон ажиллана.

4.1.1.Дулааны эрчим хүч. Нэр томъёо, тодорхойлолт MNS 5085:2001;

4.1.2.Орон сууц, олон нийтийн барилга. Өрөөний бичил уур амьсгалын үзүүлэлт MNS 5825:2007;

4.1.3.Орон сууцны барилга-халаалтын дулааны эрчим хүчний хувийнзарцуулалтыг тодорхойлох арга MNS 5827:2007;

Тав. Дулааны эрчим хүчний төлбөрийн нөхцөлийг тусгасан хэм хэмжээ

5.1 Төлбөр тооцооны ерөнхий нөхцөл:

5.1.1.Дулааны эрчим хүчээр хангах гэрээнд тусгагдсан дулааны тоолуур, усны тоолуурын заалт, барилгын эзлэхүүн, талбай, зураг төслийн тооцоот хүчин чадал, хүний тоо нь дулааны эрчим хүчний төлбөр тооцооны үндэслэл болно.

5.1.2.Дулааны эрчим хүчний үйлчилгээний тарифыг айл өрхийн халаалтын төлбөр тооцох талбайн хэмжээнд үндэслэн тогтооно.

5.1.3. Дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ээлжит их засвар, гэмтэл саатлаас шалтгаалан дулааны эрчим хүчээр хэрэглэгчийг хязгаарласан тохиолдолд хязгаарласан хоногт ногдох дулааны үйлчилгээний тарифыг тухайн сарын дулааны үйлчилгээний тарифаас хасаж тооцно.

5.1.4. Хэрэгцээний халуун усны систем нь хамааралгүй схемээр буюу ус, дулаан дамжуулах төв, цогц төхөөрөмжийн дараагаас холбогдсон, буцах шугамтай хэрэглэгчийн халуун усны системийг дулааны тоолуур суурилуулах техникийн боломжгүй хэрэглэгч гэж үзнэ.

5.1.5. Хэрэглэгч дулаанаар хангагдах барилга байгууламжийн эзэлхүүн, талбай, хэрэгцээний халуун усны ачааллыг гэрээнд зөв тусгуулаагүй болон холболтыг өөрчлөх, эзлэхүүн, талбайг нэмэх, багасгасан нь илэрсэн бол энэ тухай акт үйлдэн дээрх зөрчилд нөхөн төлбөр ногдуулна. Нөхөн төлбөрийг тооцох хугацааг тодорхойлох боломжтой бол холбогдох баримтыг хавсаргах ба хугацааг тодорхойлох боломжгүй нөхцөлд дулаан авахаар гэрээнд заасан хугацаанаас эхлэн нөхөн төлбөр ногдуулна.

5.1.6. Хэрэглэсэн дулааны эрчим хүчний төлбөрийн нэхэмжлэл банкинд очсоноос хойш алданги тооцож эхлэх болон дулааны эрчим хүчээр түдгэлзүүлж эхлэх хоногуудыг тус тус хэрэглэгчтэй байгуулж буй гэрээгээр зохицуулна.

5.1.7. Дулаан хангамжийн горимын зөрчил, шугам тоног төхөөрөмжийн гэмтэлтэй холбоотой хэрэглэгчийн санал, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх ба дулааны эрчим хүч дутуу нийлүүлсэн, эрчим хүчээр хязгаарласан буюу тасалсан эрчим хүчний хэмжээг тоолуурын заалт, ээлжийн диспетчерийн албан ёсны тэмдэглэл, параметрийн мэдээ, хэрэглэгчийн дуудлагын бүртгэлийг үндэслэн төлбөрийн хасалтыг хийнэ.

5.1.8. Хэрэглэгч төлбөр тооцооны маргаантай асуудлаарх санал, хүсэлтээ хангагчид албан ёсоор мэдэгдэх ба хангагч мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.

5.1.9. Төлбөр тооцооны хэмжих хэрэгсэлтэй холбогдсон маргааныг хэмжил зүйн улсын байцаагч, төлбөр тооцоотой холбоотой маргааныг харъяалалын дагуу хангагч байгууллага тус тус шийдвэрлэнэ. Төлбөр тооцоотой холбоотой маргааныг хангагчийн зүгээс шийдвэрлэсэн шийдвэрийг хэрэглэгч эс зөвшөөрвөл ЭХЗХ-нд хандан шийдвэрлүүлж болно.

5.1.10. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчээр Эрчим хүчний зохицуулах хорооны боловсруулсан аргачлалын дагуу төлбөрт үйлчилгээ хийлгэж болно.

5.1.11. Үйлчилгээтэй орон сууцны үйлчилгээний хэсэг болон оффиссын барилгыг хэсэгчлэн өмчилсөн тохиолдолд дангаар өмчилсөн хэсгийн дулааны эрчим хүчний төлбөрийг дулааны тоолуур эсхүл эзэлхүүнээр тооцон төлөх ба дундын эзэмшлийн өөрт ногдох хэсгийн халаалтын төлбөрийг нэмж төлнө.

5.2. Тоолууртай хэрэглэгчийн төлбөр тооцох нөхцөл:

5.2.1. Эрчим хүчний тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтад заасан шаардлагыг хангасан дулааны тоолуурыг дулааны эрчим хүчний төлбөр тооцоонд ашиглах бөгөөд дулааны тоолуур суурилуулах техникийн боломжгүй хэрэглэгчдийн хэрэгцээний халуун ус халаасан дулааны төлбөр тооцоонд усны тоолуурыг ашиглана.

5.2.2. Дулааны тоолуур, усны тоолуурыг хэмжил зүйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага холбогдох стандартын дагуу суурилуулах бөгөөд тооцоонд авахдаа дараах материалын бүрдлийг хангуулсан байна.

5.2.2.1. тоолуур суурилуулсан протокол;

5.2.2.2. тооцоонд хүлээж авсан тухай акт;

5.2.2.3. баталгаажилтын гэрчилгээ;

5.2.3. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.3-т заасны дагуу хангагч нь хэрэглэгчийн хүсэлтээр эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан дулааны тоолуурыг холболтын цэгт суурилуулах, эрх бүхий байгууллагаас суурилуулсан дулааны тоолуурын холболтыг шалгаж битүүмжлэн энэ дүрмийн 5.2.2-т заасны дагуу хүлээн авч төлбөр тооцоонд ашиглана.

5.2.4. Хангагчийн эрх бүхий ажилтан нь тухайн хэрэглэгчийн тоолуурын лац ломбоны бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хянаж сард 2-оос доошгүй удаа тоолуурын тооцооны хуудас дээр параметрийн тэмдэглэгээ хийж хэрэглэгчийн эрх бүхий төлөөлөгчийн гарын үсгээр баталгаажуулна. Энэхүү хуудсыг үндэслэн сарын төлбөр тооцоог хийх бөгөөд үүнээс гадна энэ нь буцах усны температурын өндөржилтийг тооцох үндсэн баримт болно.

5.2.5. Дулааны эрчим хүчний тооцоог тоолуураар хийж байгаа хэрэглэгчийн хэрэглэсэн дулааны эрчим хүчний тоо хэмжээн дээр "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 42 дахь заалтыг үндэслэн дулааны шугамын алдагдлыг 5 хүртэл хувиар нэмжтооцно.

5.2.6. Дулааны болон усны тоолуур нь ашиглалтын явцад холболт, тохируулгын буруутай үйлдэл, тоолуурыг дур мэдэн таслах, лац ломбо гэмтээсэн болон гадны нөлөөллөөр заалт буруу гарсан бол тоолуурын заалтыг хэрэгсэхгүй болгон төлбөрийг зураг төслөөр тооцсон хүчин чадлыг үндэслэн /задгайгаар/ нөхөн тооцно.

5.2.7. Дулааны болон усны тоолуур нь ашиглалтын явцад гэмтэх, эвдрэх, тоолуурын тэжээлийн доголдол гарах нь хэрэглэгчээс шалтгаалаагүй болохыг хэмжүүрийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоосон тохиолдолд усны тоолуураар тооцдог бол өмнөх 3 сарын дунджаар, дулааны тоолуураар тооцдог бол халаалтын улиралд /тухайн хэрэглэгчийн дулааны ачаалалд өөрчлөлт ороогүй бол/ өмнөх оны тухайн сарын дулааны хэмжээг гадна

агаарын температураас хамааруулан, халаалтын бус улиралд тухайн улирлын хамгийн их хэрэглээгээр тус тус нөхөн тооцно.

5.2.8.Тоолуурыг баталгаажуулах болон бусад шалтгаанаар салгах бол хангагч, хэрэглэгчийн эрх бүхий төлөөлөгчийг байлцуулан лац, ломбоны бүрэн бүтэн байдал болон бусад зүйлийг шалган акт үйлдэнэ.

5.2.9.Хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмж дээр суурилуулсан нэмэлт усны тоолуурын заалтыг үндэслэн нэмэл тустай хамт алдагдаж байгаа дулааны энерги болон нэмэлт усны төлбөрийг хэрэглэгчээс тооцон авна.

5.2.10.Дулааны эрчим хүчээр хангагдаж байгаа хэрэглэгч нь сүлжээний буцах усны халууныг батлагдсан графикаас 4 хэмээс дээш хэмжээгээр өндөржүүлсэн тохиолдолд өндөржүүлсэн хэмд ногдох ашиглахгүй буцаасан дулааны үнийг тооцож буцах усны температур өндөржсөнд ногдох дулааны төлбөрийг бусад хэрэглэсэн дулааны төлбөрийн нэгэн адил төлүүлнэ.

5.3.Тоолуургүй хэрэглэгчийн төлбөртооцох нөхцөл

5.3.1.Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурилагдаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзэлхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно. Орон сууцны барилгыг ахуйн зориулалтаар нь ашиглаж, хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, үүнээс бусад нөхцөлд эзэлхүүнээр тооцно.

5.3.2.Дулааны тоолуургүй, эсхүл усны тоолуургүй хэрэглэгчийн салхилуулга, ахуйн ба технологийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааны эрчим хүчийг тодорхойлохдоо тухайн барилга объектын хянагдсан зураг төслийн хүчин чадлын 75 хувиар тооцно.

5.3.3.Өөрийн тусгайлсан зураг төслөөр баригдсан барилга, объект бүхий дулааны тоолуургүй, эсхүл усны тоолуургүй хэрэглэгчдэд энэхүү дүрмийн 5.3.2 дахь заалт нэгэн адил хамаарна.

5.3.4.Аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан барилгад, дулааны тоолуур суурилуулах боломжгүй тохиолдолд халаалтын төлбөрийг эзлэхүүнээр тооцно. Тухайн барилгын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг өрөөний урт, өргөн, өндөр/давхрын бодит өндөр/-ийн хэмжээгээр тодорхойлно. Анхны батлагдсан зургаас өөр зориулалтаар уг барилгыг ашиглах бол мэргэжлийн байгууллагын дүгнэлт, дулааны эрчим хүчээр найдвартай хангах техникийн хувьд боломжтой эсэх тооцоог үндэслэн эх үүсвэрийг тогтооно.

5.3.5.Айл өрхийн халаалтын төлбөрийг дулааны тоолуураар тооцох боломжгүй тохиолдолд Монгол Улсын MNS 6058:2009 стандарт /Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал/-д заасан сууцны болон сууцны бус зориулалттай талбайн нийлбэрээр тооцно. Уг стандартын холбогдох заалтыг үндэслэн айл өрхийн халаалт тооцох талбайн хэмжилтийг хийнэ.

5.3.6.Халаах хэрэгсэлгүй боловч бусад халаах хэрэгсэл бүхий өрөө, тасалгааны дулаан солилцоогоор халж хэвийн үйл ажиллагаа явуулах орчин бүрдсэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй барилгын халаалтыг эзлэхүүнээр, орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа барилгын халаалтыг талбайгаар тооцно.

5.3.7.Орон сууцны барилгын орцны халаалтын төлбөрийг халаах хэрэгсэл бүхий давхрын талбайн хэмжигдэхүүн (метр квадрат)-ээр тооцох ба сууц өмчлөгч нь дундын өмчлөлийн орцны халаалтын төлбөрийг Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.2 дахь заалтыг үндэслэн дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид хангах гэрээний дагуу төлж болно.

5.3.8.Талбайн хэмжигдэхүүнээр дулааны эрчим хүчний төлбөр тооцогдож байгаа аливаа барилга, байгууламж, орон сууцанд аж ахуйнүйл ажиллагаа явуулсан нөхцөлд тухайн хэсгийн дулааны төлбөрийг эзлэхүүнээр тооцно.

5.3.9.Орон сууцны барилгын зориулалтыг өөрчлөн тусгайлан хаалга гадагш гаргаж аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа бол үйл ажиллагаа явуулж байгаа талбайгаас эзлэхүүнээр, бусад хүн амьдарч буй талбайгаас талбайн хэмжигдэхүүнээр тооцно.

5.3.10.Орон сууцны барилгын подвалд халаах хэрэгсэл /регистр, усан агаар халаагч/ суурилагдсан тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа бол эзлэхүүнээр тооцно.

5.3.11.Барилгын подвалд халаах хэрэгсэл /регистр, усан агаар халаагч хэвийн ажиллаж байгаа/ суурилагдсанавто зогсоолын зориулалтаар ашиглаж байгаа бол дулааны эрчим хүчний төлбөрийг талбайн хэмжигдэхүүнээр тооцох ба халаалтын төлбөр тооцох талбайн хэмжээг халаах хэрэгсэл бүхий зоорийн давхрын нийт талбайн 50%-иар тооцно.

5.3.12.Подвалд халаах хэрэгсэл суурилуулаагүй бөгөөд барилгын дулааны гол зангилаа, тараалтын шугамын дулаалга холбогдох норм дүрэм, стандарт /"Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт/-д нийцээгүй, дулаан солилцоо явагдаж байгаа тохиолдолд халаалтын төлбөрийг 5.3.11-д заасны дагуу тооцно.

5.3.13.Подвалд халаах хэрэгсэл суурилуулаагүй бөгөөд барилгын дулааны гол зангилаа, тараалтын шугамын дулаалга холбогдох норм дүрэм, стандарт /"Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт/-д нийцсэн тохиолдолд актаар баримтжуулан гэрээнд тусгаснаар халаалтын төлбөр тооцохгүй.

5.3.14.Нийтийн авто зогсоол эзэмшигч буюу өмчлөгч нь өөрийн эзэмшлийн зогсоолын болон дундын эзэмшлийн өөрт ногдох хэсгийн халаалтын төлбөрийг хариуцна.

5.3.15.Дулааны тоног төхөөрөмж, шугам, сүлжээ эвдэрч гэмтсэнээс байрны халаалтыг хаасан тохиолдолд хаасан хоногт /цагт/ ногдох халаалтын төлбөрийг тухайн сарын хэрэглэгчийн халаалтын төлбөрөөс хасаж тооцох бөгөөд уг төлбөрийг буруутай этгээд хариуцна.

Зургаа. Дүрмийн биелэлтэнд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага

6.1.Энэхүү дүрмийн биелэлтэнд хангагч, хэрэглэгч талууд болон Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч хяналт тавина.

6.2.Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд Эрчим хүчний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----